



**ТӨРИЙН АУДИТЫН
БАЙГУУЛЛАГА**

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН АУДИТЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛД

**МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ,
ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТАД ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН
ТАЙЛАНГИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

2024.06.18

ᠡᠷᠦᠨᠬᠢᠶᠢ
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯᠡᠯᠢ


ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ




ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ

Говьсүмбэр аймгийн хэмжээнд тоологдсон
малын тоо / мянган толгой /



Сумдын нэг толгой малд ногдох татварын хэмжээ



Бүх сумд тэмээг татвараас чөлөөлсөн

Сүмбэр сум 800, Шивээговь, Баянтал сум ижилхэн 1000 төгрөг



Нэг өрхийн малын төрөл бүрээс Малын тоо толгойн албан татварын хөнгөлөлт үзүүлэх малын тоо



Шивээговь сум татвараас хөнгөлөөгүй

Сүмбэр сум адуу, үхэр 20 толгой, хонь 150, ямаа 100 толгой



Баянтал сум хонь, ямаа 50 толгой



Сүмбэр сум 500, Шивээговь сум 800, Баянтал сум 1000

Бүх сумд ялгаагүй 300 төгрөг



Сүмбэр сум 300, Шивээговь сум 800, Баянтал сум 500





Аудитаар нийт 828.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс, малын тоо толгойн албан татварын орлогыг үнэн зөв үндэслэлтэй тооцоолох, багийн ИНХ-аас гаргасан саналын эрэмбэ, хууль журамд заасан чиг үүргийн хүрээнд, малчдын амьдралд үр өгөөжөө өгөхүйц бодитой хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээнд зарцуулахтай холбоотой 62.5 сая төгрөгийн 5 зөвлөмж, зөрчлийг арилгуулах давтан гаргахгүй байх 766.1 сая төгрөгийн 7 албан шаардлага өглөө.





Аудитын илрүүлэлт: №1

Шивээговь, Баянтал сумд 2022, 2023 оны Малын тоо толгойн албан татварын орлогын тооцооллыг ирүүлээгүй, хэрхэн тооцоолсон нь тодорхойгүй байсан ба Татварын газрын ногдуулсан дүнгээс 2022 онд 6,135.9 мянган төгрөгөөр илүү, 2023 онд Шивээговь сум 15,696.2 мянган төгрөгөөр илүү, Баянтал сум 15,630.9 мянган төгрөгөөр дутуу төлөвлөсөн.

Сумдын нэрс	2022 оны орлогын төлөвлөгөө	2022 оны Татварын газрын ногдуулсан дүн	Зөрүү	2023 оны орлогын төлөвлөгөө	2023 оны Татварын газрын ногдуулсан дүн	Зөрүү
Сүмбэр	80,729.8	88,446.8	-7,717.0	84,839.7	87,313.6	-2,473.9
Шивээговь	36,073.1	30,938.3	5,134.8	45,000.0	29,303.8	15,696.2
Баянтал	27,432.5	26,431.4	1,001.1	19,000.0	34,630.9	-15,630.9
Дүн	144,235.4	145,816.5	-1,581.1	148,839.7	151,248.3	-2,408.6

Хүснэгтээс харахад: Сүмбэр сум 2022, 2023 онд Татварын газрын ногдуулсан дүнгээс 2.8-8.7%-иар бууруулсан бол Шивээговь сум 16.6-53.6%-иар нэмэгдүүлсэн, Баянтал сум 2022 онд 3.8%-иар нэмэгдүүлж, 2023 онд 45.1%-иар бууруулж баталсан байна.

Зөрчигдсөн хууль тогтоомж:



- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2 дугаар зүйлийн 2.7

2.7. Сум, дүүргийн ИТХ малын тоо толгойн албан татварын тухайн жилийн орлогыг тооцон баталж, баталснаас хойш ажлын 5 хоногийн дотор аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ. Аймаг, нийслэл Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүргүүлнэ.



Аудитын шийдвэр: Зөвлөмж №1

Сумдын Засаг дарга нарт: Өмнөх оны малын тоо толгойн статистик мэдээнд үндэслэн тухайн жилийн малын тоо толгойн албан татварын орлогыг үнэн зөв, үндэслэлтэй тооцоолох, хариуцсан багийн Засаг дарга нар, санхүүгийн албаны дарга мэргэжилтнүүдэд үүрэг чиглэл өгч хариуцуулах





Аудитын илрүүлэлт: №2

Сумд малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөг 2022 онд 51.5 хувь, 2023 онд 39.1 хувиар тус тус дутуу төвлөрүүлж, төлөвлөгөөг бүрэн биелүүлээгүй.

Сумдын нэрс	2022		Хэрэгжилтийн хувь	2023		Хэрэгжилтийн хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Сүмбэр	80,729.8	49,252.9	61.0	84,839.7	68,797.3	81.1
Шивээговь	36,073.1	8,035.4	22.3	45,000.0	13,462.9	29.9
Баянтал	27,432.5	12,687.5	46.3	19,000.0	8,443.3	44.4
Нийт	144,235.4	69,975.8	48.5	148,839.7	90,703.5	60.9

Хүснэгтээс харахад: Малын тоо толгойн албан татварын орлогын хэрэгжилт 2022 онд 48.5%, 2023 онд 60.9%-тай байна.



Зөрчигдсөн хууль тогтоомж:

- Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 , 23.8.15 , 41 дүгээр зүйлийн 41.2 , 41.2.1

23.8 Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ:

23.8.15 малын тоо толгойн албан татвар

41.2 Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ

41.2.1 Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх

Аудитын шийдвэр: Албан шаардлага №1



Сумдын Засаг дарга нарт: Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэх, хэрэгжилтийг хангах чиглэлээр аймгийн Татварын газар, аймгийн СТСХ зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах, малчид мал бүхий этгээдэд сургалт сурталчилгаа тогтмол хийх



ᠭᠣᠪᠢᠰᠦ᠋ᠮᠦ᠋ᠪᠦᠷ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ ᠲᠦᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠤᠳᠢᠶᠢᠨ ᠭᠠᠵᠠᠷ

Аудитын илрүүлэлт: №3



Аймгийн Татварын газар нь 2022 онд 86,127.5 мянга, 2023 онд 75,915.9 мянган төгрөгийн малын тоо толгойд ногдуулсан албан татварыг төсөвт төвлөрүүлээгүй, төвлөрүүлэх чиглэлээр Шивээговь, Баянтал сумдын Засаг дарга нартай хамтран ажиллаагүй, сургалт сурталчилгааг тогтмол хийгээгүй

Тайлант он	Нэхэмжлэхийн дүн	Урьд оны барагдуулалт	2023 оны барагдуулалт	Өрийн үлдэгдэл	Барагдуулалтын хувь
2022	151,248.3	9,517.7	81,377.3	86,127.5	53.8
2023	145,816.5	36,020.2	33,880.4	75,915.9	23.23
Нийт	297,064.8	45,537.9	115,257.7	162,043.4	38.8

Хүснэгтээс харахад: Аймгийн Татварын газраас ирүүлсэн судалгаагаар малын тоо толгойд ногдуулсан албан татвараас 2022 онд 86,127.5 мянга, 2023 онд 75,915.9 мянган төгрөгийн татварыг төсөвт тус тус төвлөрүүлээгүй бөгөөд татвар хураалт 2022 онд 53.8 хувь, 2023 онд 23.2 хувьтай байгаа нь өмнөх оноос 50%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Зөрчигдсөн хууль тогтоомж:

- ❑ Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 , 23.8.15,
- ❑ Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 , 7.2,
- ❑ ТЕГ-ын даргын 2021 оны А/09 дүгээр тушаалаар батлагдсан “Малын тоо толгойн албан татвар ногдуулах, төлөх, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1

Аудитын шийдвэр: Албан шаардлага №2

Малын тоо толгойд ногдуулсан албан татварын нийт 162,043.4 мянган төгрөгийн өрийг барагдуулах, өмнөх оны өр барагдуулах чиглэлээр сумдын Засаг дарга нартай хамтран ажиллах



Аудитын илрүүлэлт: №4

Малын тоо толгойн албан татварын орлогыг малчид, мал бүхий этгээдээс санал авалгүй 2022, 2023 онд нийт 48 төсөл арга хэмжээний жагсаалтыг гаргаж баталсан байна.



Зөрчигдсөн хууль тогтоомж:

- ❑ Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6,
- ❑ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар хэсгийн 6.10,
- ❑ Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12 дугаар зүйлийн 12.2.1

№	Сумдын нэр	Батлагдсан ТАХ-ний тоо		Батлагдсан ТАХ-нд малчдын саналаар эрэмбэлэгдсэн ТАХ-ний тоо		Ажлын хэсгээс нэмж баталсан ТАХ-ний тоо	
		2022 он	2023 он	2022 он	2023 он	2022 он	2023 он
1	Сүмбэр сум	20	13	3	1	17	12
2	Баянтал сум	10	1	-	1	10	-
3	Шивээговь сум	6	8	2	5	4	3
Нийт дүн		36	22	5	7	31	15

Хүснэгтээс харахад: 2022-2023 онд нийт 58 төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс малчдын саналаар 20% буюу 12, ажлын хэсгээс 80% буюу 46 төсөл, арга хэмжээг нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

Аудитын шийдвэр: Зөвлөмж №2



Багийн ИНХ-аас гаргасан эрэмбэлсэн саналын дагуу хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг санхүүжүүлэх

Сүмбэр сум
Баянтал сум
Шивээговь сум
Нийт дүн



Аудитын илрүүлэлт: №5

Сумын ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгийг ХХААХҮС-тай байгуулсан гэрээнд "Тухайн орон нутагт төвлөрсөн малын тоо толгойн албан татварын 30-аас доошгүй хувийг малчдын малын эрүүл мэндийг хамгаалах зайлшгүй шаардлагатай үйл ажиллагаанд зарцуулна" гэж зааснаар МЭГ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу малчид, мал бүхий этгээдээс санал авалгүй мал угаалгын төлбөрт нийт 36,154.4 мянган төгрөгийг шилжүүлсэн, босго үнээс хэтэрсэн боловч худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, давуу эрх олгосон.

- Сүмбэр сум МЭГ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу малчид, мал бүхий этгээдээс санал авалгүй 2022 оны мал угаалгын төлбөрт 25,000.0 мянган төгрөгийг “Хийморь-Алтай” МЭҮН-д шилжүүлсэн, шууд худалдан авах босго үнээс давсан байхад худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, гүйцэтгэгч байгууллагад давуу эрх олгосон
- Шивээговь сум малчид, мал бүхий этгээдээс санал авалгүй 2022 оны мал угаалгын төлбөрт 7,900.0 мянган төгрөгийг “Хийморь-Алтай” МЭҮН-д шилжүүлсэн
- Баянтал сум МЭГ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу малчид, мал бүхий этгээдээс санал авалгүй 2022 оны мал угаалгын төлбөрт 3,254.4 мянган төгрөгийг “Хилийн Дэлгэрэх” МЭҮН-д шилжүүлсэн

Зөрчигдсөн хууль тогтоомж:

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 6 дугаар хэсгийн 6.10, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12 дугаар зүйлийн 12.2.1

Аудитын шийдвэр: Албан шаардлага №3

Багийн ИНХ-аас гаргасан саналын эрэмбийн дагуу Малын тоо толгойн албан татварын орлогоор хийгдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналыг боловсруулж батлуулах, худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулах





Аудитын илрүүлэлт: №6


Аудитын илрүүлэлт: №6

Сүмбэр, Баянтал сум нийт 8,833.2 мянган төгрөгийн төсөл арга хэмжээг хууль, журамд заасан чиг үүргийн дагуу зарцуулаагүй.

Баянтал сум-2,500.0 мянга /Газарзүйн байршилын цэг тэмдэглэгээ тогтоох ажлыг зохион байгуулах /



Сүмбэр сум-6,333.2 мянга /Малчдын өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдалтай танилцах, Пос машин худалдан авах, өвөлжөө хаваржааны солбилцол тодорхойлох /



Зөрчигдсөн хууль тогтоомж:

- ❑ Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8 ,
- ❑ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.5

60.2.8 малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамигаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна

4.5 Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр дараах чиг үүргийн хүрээнд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.

Аудитын шийдвэр: Зөвлөмж №3

Малын тоо толгойн албан татварын орлогоор санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг хууль, журамд заасан чиг үүргийн хүрээнд зарцуулах



Аудитын илрүүлэлт: №7

2022, 2023 онд малын тоо толгойн албан татварын орлогоос хөрөнгө оруулалтын шинжтэй ажил хийгдээгүй, зөвхөн урсгал зардалд зарцуулагдсан

Баянтал сум-2,500.0 мянга /Газарзүйн байршлын цэг тэмдэглэгээ тогтоох ажлыг зохион байгуулах /



Сүмбэр сум-6,333.2 мянга /Малчдын өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдалтай танилцах, Пос машин худалдан авах, өвөлжөө хаваржааны солбицол тодорхойлох /

Баянтал сум	<ul style="list-style-type: none"> • Мал угаалгын хашаа-4,500.0 /үндсэн хөрөнгө/ • Утагч-2,196.0 /бараа материал/ • Нүх ухагч-3,250.0 /бараа материал/
Сүмбэр сум	<ul style="list-style-type: none"> • Өвс тэжээл-16,050.0 /бараа материал/ • Пос машин-1,000.0 /бараа материал/
Шивээговь сум	<ul style="list-style-type: none"> • Өвс тэжээл-8,500.0 /бараа материал/

Зөрчигдсөн хууль тогтоомж:

- ❑ Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8,
- ❑ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.5
- ❑ Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6,
- ❑ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 5 дугаар хэсгийн 5.1, 6 дугаар хэсгийн 6.10,
- ❑ Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журм хэсгийн 12.2.1



Аудитын шийдвэр: Зөвлөмж №4

Малчид, мал бүхий этгээдийн саналаар дэмжигдсэн, малчдын амьдралд үр өгөөжөө өгөхүйц бодитой хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд түлхүү зарцуулахад анхаарч ажиллах



Аудитын илрүүлэлт: №8

Шивээговь, Баянтал сумын ИТХ малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй

Сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга нараас “2022-2023 оны малын тоо толгойн албан татварын орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавьж ажилласан уу?” гэж асуухад хяналт тавьж ажилласан гэж хариулсан боловч аудитын явцад Шивээговь, Баянтал сумдаас хяналт хэрэгжүүлсэн нотлох баримт ирүүлээгүй. Сүмбэр сумын ИТХ 1 удаа зөвлөмж хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилтийг зөвлөлийн хурлаар хэлэлцсэн байна.

Зөрчигдсөн хууль тогтоомж:

- ❑ Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6,
- ❑ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 5 дугаар хэсгийн 5.1, 6 дугаар хэсгийн 6.10,
- ❑ Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12 дугаар хэсгийн 12.2.1



Аудитын шийдвэр: Зөвлөмж №5

Шивээговь, Баянтал сумдын ИТХ хуулийн хэрэгжилт, орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавьж, биелэлтийг тооцож ажиллах



Аудитын илрүүлэлт: №9

ОНХС-ийн УМС-д 2022 онд 208,247.8 мянга, 2023 онд 227,266.2 мянган төгрөгийн малын тоо толгойн албан татварын орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын тайланг оруулаагүй.

- Сүмбэр сум 2022 онд 150,220.1 мянга, 2023 онд 194,803.3 мянган төгрөгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын тайланг оруулаагүй
- Шивээговь сум 2022 онд 11,120.5 мянга, 2023 онд 13,462.9 мянган төгрөгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын тайланг оруулаагүй
- Баянтал сум 2022 онд 46,907.2 мянган төгрөгийн орлогын бүрдүүлэлт оруулаагүй

Зөрчигдсөн хууль тогтоомж:

- ❑ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар хэсгийн 3.2.3 , 3.4.5

3.2.3 ЗДТГ-ын албан тушаалтанд өгч, тус албан тушаалтан Удирдлага мэдээллийн системд оруулна

3.4.5 ОНХС-гийн Удирдлага мэдээллийн системийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт цэсэд ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний мэдээллийг бүрэн оруулах”



Аудитын шийдвэр: Албан шаардлага №4

Сумд Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтыг ОНХС-ийн УМС-д нөхөн мэдээлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх, иргэд олон нийтийг мэдээллээр бүрэн хангах



ДҮГНЭЛТ

Бүлэг-1. Малын тоо толгойн албан татварын орлогыг үнэн зөв, бүрэн төлөвлөөгүй, төлөвлөсөн орлогыг дутуу бүрдүүлсэн байна.

1.1. Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөг үнэн зөв төлөвлөөгүй байна.

1.2. Малын тоо толгойн албан татварыг хуульд заасны дагуу бүрэн бүрдүүлээгүй, холбогдох байгууллагуудын хамтын ажиллагаа үр дүнгүй байна.

1.3. Малын тоо толгойн албан татварыг хуульд заасны дагуу бүрэн тайлагнасан байна.

Бүлэг-2. Малын тоо толгойн албан татварын орлогыг журмын дагуу зарцуулаагүй байна.

2.1. Малын тоо толгойн албан татварын орлогыг малчид, мал бүхий этгээдийн саналаар эрэмбэлэн батлуулсан төсөл, арга хэмжээнд зарцуулаагүй, нийт зарцуулалтын 74%-ийг урсгал зардалд зарцуулсан байна.

2.2 Малын тоо толгойн албан татварын орлогоор санхүүжүүлсэн нийт зарцуулалтын 74%-ийг урсгал зардалд зарцуулсан нь үр өгөөж муутай байна.

Бүлэг-3. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилтэд чиг үүрэг бүхий байгууллагууд хяналт хэрэгжүүлээгүй байна.

3.1 Малын тоо толгойн албан татварын орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй, удирдлага мэдээллийн системд бүрэн мэдээлээгүй байна.





ЗӨВЛӨМЖ

Шивээговь, Баянтал сумын ИТХ-д:

1. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих, биелэлтийг тооцох

Сумдын Засаг дарга нарт:

1. Өмнөх оны малын тоо толгойн статистик мэдээнд үндэслэн тухайн жилийн малын тоо толгойн албан татварын орлогыг үнэн зөв, үндэслэлтэй тооцоолох, хариуцсан багийн Засаг дарга нар, санхүүгийн албаны дарга мэргэжилтнүүдэд үүрэг чиглэл өгч хариуцуулах
2. Багийн ИНХ-аас гаргасан саналын эрэмбийн дагуу төсөл арга хэмжээг санхүүжүүлэх
3. Малын тоо толгойн албан татварын орлогыг малчид, мал бүхий этгээдийн саналаар дэмжигдсэн, малчдын амьдралд үр өгөөжөө өгөхүйц, бодитой хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд түлхүү зарцуулахад анхаарч ажиллах
4. Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг хууль, журамд заасан чиг үүргийн хүрээнд санхүүжүүлэх



ᠨᠣᠲᠯᠤᠬᠤ ᠪᠠᠷᠢᠮᠲᠤ
ᠪᠣᠯᠤᠨ ᠠᠵᠯᠢᠨ
ᠪᠠᠷᠢᠮᠲᠤᠭᠤᠳᠤ

НОТЛОХ БАРИМТ
БОЛОН АЖЛЫН
БАРИМТУУД



АУДИТЫН НОТЛОХ БАРИМТ БОЛОН АЖЛЫН БАРИМТУУДЫН ЖАГСААЛТ

1. НИЙЦЛИЙН АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ
2. НИЙЦЛИЙН АУДИТЫН ХӨТӨЛБӨР
3. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ МЭДЭГДЛҮҮД
4. НУУЦЫН БАТАЛГАА
5. НӨЛӨӨЛЛИЙН МЭДҮҮЛЭГ
6. АУДИТЫН НЭЭЛТИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ
7. ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛЫН ТӨСӨЛ
8. ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛ
9. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДЛЫН БҮРТГЭЛИЙН ТӨСӨЛ
10. ТӨЛБӨРИЙН АКТ, АЛБАН ШААРДЛАГЫН ТӨСӨЛ
11. АУДИТААР ТООЦСОН ҮР ӨГӨӨЖ
12. НОТЛОХ БАРИМТУУД 1, 2
13. АЖЛЫН БАРИМТУУД



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД ТАЛАРХЛАА

